

# РАДИО ДОЛГИОНЫ АШИГЛАЛТЫН БАЙДАЛД ХЯНАЛТ ТАВИХ, ҮР ДҮНГ ТАЙЛАГНАХ ЖУРАМ

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Монгол Улсын Харилцаа Холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйл, Радио долгионы тухай хуулийг үндэслэн Монгол Улсын нутаг дэвсгэрт радио долгионы хяналт хийх, үр дүнг тайлагнах явцад үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид “Зохицуулах хороо” гэх/ нь радио долгионы хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ радио давтамж ашиглагчийн үйл ажиллагаанд саад хохирол учруулахгүйгээр мэргэжлийн түвшинд, шуурхай зохион байгуулна.

## Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Төлөвлөгөөт хяналт гэж Зохицуулах хорооны тухайн жилийн бүтээгдэхүүн нийлүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг;

2.2. Төлөвлөгөөт бус хяналт гэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, гомдлын дагуу болон бусад хяналт, шалгалтын ажлыг;

2.3. Өөрийн хариуцсан хяналтын төхөөрөмж гэж байгууллагын эд хөрөнгийн бүртгэлд тухайн этгээдийн нэр дээр бүртгэлтэй төхөөрөмжийг;

## Гурав. Радио долгионы хяналтын үйл ажиллагаа

3.1. Радио долгионы хяналтын үйл ажиллагааг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу дор дурьдсан чиглэлээр зохион байгуулна. Үүнд:

- Радио тоног төхөөрөмжийн давтамжийн цараа, долгион цацаргалт, оновчтой байршлыг тодорхойлох, дүн шинжилгээ хийх;
- Радио давтамж ашиглан үйлчилгээ эрхлэгч байгууллага, аж ахуйн нэгж, иргэний ашиглаж буй тоног төхөөрөмж нь техник, технологийн болон ашиглалтын стандарт, нормын шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах, тогтоох;
- Хууль ёсны радио долгион ашиглагчдын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор хууль бус хэрэглээг илрүүлэх, үйл ажиллагааг нь зогсоох;
- Монгол улсад импортоор оруулж ирж байгаа радио тоног төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, хэмжилт, шалгалт хийх;
- Олон улсын радио долгионы хяналтад оролцох;
- Хэрэглэгчийн хүсэлт, гомдлын дагуу радио давтамжийн харилцан нөлөөллийн эх үүсгүүрийг тогтоох зорилгоор хэмжилт хийх, шаардлагатай арга хэмжээг авах;
- Харилцаа холбооны салбарт мөрдөгдөж буй хууль, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, арга хэмжээ авах;
- Радио долгион ашиглах байгууллага, иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх;
- Радио долгионы үүсгэх цахилгаан соронзон оронгийн хүчлэгийн хэмжээг тогтоох хэмжилт хийх, дүгнэлт гаргах;

- Радио телевизийн олон суваг дамжуулах тоон өргөн нэвтрүүлгийн газрын сүлжээ, үүрэн холбоо, өргөн зурвасын өндөр хурдны утасгүй интернетийн хамрах хүрээний болон чанарын хэмжилт, тооцоолол хийх;

#### **Дөрөв. Радио долгионы хяналтын бүтэц, зохион байгуулалт**

4.1. Радио долгионы хяналтыг радио долгионы хяналтын төвийн дарга, ахлах инженер, суурин хяналтын инженер, хөдөлгөөнт хяналтын инженер, хяналтын инженер, явуулын хяналтын станцын жолооч (механик) нар хариуцан гүйцэтгэнэ.

4.2. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хэмжилт, хяналт шалгалтыг төвийн дарга, ахлах инженер нь удирдан зохион байгуулна.

4.3. Хяналтын ахлах инженер нь хяналтын инженерүүдийн хэмжилт, шалгалтын ажлыг ажлын ачааллаас хамааруулан тухай бүр хуваарилаж, зааварчилгаа өгнө.

4.4. Хяналтын инженерүүд нь иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн хүсэлт, гомдлын дагуу радио долгионы харилцан нөлөөллийг илрүүлэх хэмжилтийг хийхдээ хүсэлт ирүүлсэн байгууллагаар **Харилцан нөлөөллийн бүртгэлийн хуудас** /Маягт-1/-ыг бөглүүлэн авна.

4.5. Хяналт, шалгалт явуулахад шаардлагатай радио давтамж ашиглагчийн талаарх үнэн зөв мэдээллийг зөвшөөрөл хариуцсан холбогдох мэргэжилтнүүдээс тухай бүр гаргуулж авна.

4.6. Шаардлагатай тохиолдолд радио давтамжийн талаарх нууцлал бүхий мэдээлэлд хяналтын инженерүүд Зохицуулах хорооны Нууцын журмын дагуу нэвтрэх эрхтэй байна.

#### **Тав. Хяналтын станцын үйл ажиллагаа**

5.1. Монгол Улсын хэмжээнд радио долгионы хяналтыг суурин болон хөдөлгөөнт нөхцөлд дараах төрлийн станцуудыг ашиглан зохион байгуулна. Үүнд:

- Суурин хяналтын станц,
- Явуулын хөдөлгөөнт хяналтын станц /цаашид “Явуулын станц” гэх/,
- Зөөврийн суурин хяналтын станц,
- Зөөврийн хяналтын төхөөрөмж,

5.2. Радио долгион хяналтын станцууд нь дор дурьдсан үзүүлэлтүүдийг хэмжиж тогтоох чадавхитай байна. Үүнд:

- Оронгийн хүчлэгийг тодорхойлох;
- Давтамжийг тодорхойлох;
- Дохионы тархалтын хэмжилт хийх;
- Зурвасын өргөнийг тогтоох;
- Модуляцийн төрлийг тодорхойлох;
- Чиглэл хайж, байршил тодорхойлох;

- Бусад станцууд болон чиглэл хайх системтэй огтлолцуулан нэвтрүүлэгчийн байршлыг тогтоох.

5.3. Радио долгионы хяналтын төвөөс хэмжилт, шалгалтын үед явуулын хөдөлгөөнт, зөөврийн суурин, зөөврийн хяналтын станцуудыг удирдан ажиллана.

### **Зургаа. Хэмжүүрийн тоног төхөөрөмжийн ашиглалт, үйлчилгээ**

6.1. Хяналтын ахлах инженер болон хяналтын инженерүүд нь өөрийн хариуцсан хяналтын төхөөрөмжийг ажилд бэлэн байлгаж байнгын үзлэг үйлчилгээг хийх болон бүрэн бүтэн байдлыг хариуцна.

6.2. Хяналтын инженерүүд нь хяналтын төвийн байрнаас гадуур хяналт шалгалтанд хэмжүүрийн тоног төхөөрөмж ашиглах бүртээ **Тоног төхөөрөмжийн нэгдсэн бүртгэлд** бүртгүүлж гарын үсэг зурсан байна.

6.3. Хяналтын инженер нь хэмжилт шалгалтын явцад өөрийн хариуцан ашигласан хэмжүүрийн тоног төхөөрөмж тус бүрийн **Техник ашиглалтын паспорт** /Маягт 2/-ыг хөтлөж, тэмдэглэл хийнэ.

6.4. Хэмжүүрийн тоног төхөөрөмжийг бусад инженерүүдэд шилжүүлэхдээ **Техник ашиглалтын паспорт** /Маягт 2/-ын 4 дэх хэсэг болох Хэмжүүрийн багаж хүлээлцсэн бүртгэлийг бөглөн, бүрэн бүтэн байдлыг харилцан шалгаж гарын үсэг зурж хүлээлцэнэ.

### **Долоо. Үр дүнг тайлагнах, олон нийтэд мэдээллэх**

7.1. Хяналтын инженерүүд нь төлөвлөгөөт хяналт шалгалтыг тухайн жилийн бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөгөөнд тусгагдсан хугацаанд хийж, даргын зөвлөлд тайлагнаж, байгууллагын цахим хуудсанд байршуулна.

7.2. Шаардлагатай тохиолдолд төлөвлөгөөт шалгалтын товч тайланг байгууллагын улирал тутмын сэтгүүлд нийтлүүлнэ.

7.3. Хяналтын инженерүүд нь төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг байгууллагын хяналтын картад тодорхойлогдсон хугацаанд багтаан гүйцэтгэж, үр дүнг тухайн албан байгууллага, иргэдэд албан бичгээр хүргүүлнэ.

7.4. Суурин хяналтын өдөр тутмын хэмжилтийн тайлан мэдээг сар, улирал бүр нэгтгэн даргын зөвлөлд танилцуулна.

7.5. Хэмжилт, хяналтыг хийж гүйцэтгэсэн хяналтын инженер нь хэмжилтийн тайланг **Хэмжилтийн тайлан бичих загвар** /Маягт 3/-ын дагуу бичиж, хяналтын ахлах инженерт танилцуулна.

7.6. Радио долгионы хяналтын үйл явц, цаашид авах арга хэмжээний саналыг 7 хоног тутам газрын даргад танилцуулна.

### **Найм. Хяналт, хариуцлага**

8.1. Тоног төхөөрөмжийг хүлээн авсан гэж гарын үсэг зурсан хяналтын инженер нь хэмжүүрийн төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцана.

8.2. Хэмжүүрийн багаж төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан үед Зохицуулах хорооны техникийн комисс шалгаж, шалтгааныг тодорхойлох бөгөөд авах арга хэмжээг комиссын дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

8.3. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Зохицуулах хорооны дотоод журмын дагуу холбогдох хариуцлага хүлээлгэнэ.

### **Ес. Хөдөлмөр, аюулгүй ажиллагаа**

9.1. Хяналтын инженерүүд, явуулын станцын жолооч нь антенн цамхагт болон өндөрт ажиллах, хөдөө орон нутагт томилолтоор ажиллахын өмнө хөдөлмөр хамгааллын инженерээс Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны зааварчилгааг авч ажиллана.

### **Арав. Бусад**

10.1. Байгууллагын бүтэц зохион байгуулалт, үндэсний радио долгион хяналтын техник технологийн хөгжлөөс хамааруулан энэхүү журамд тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.



**ХЭРЭГЛЭГЧИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ**

**1. Хэрэглэгчийн мэдээлэл:**

1.1 Нэр: \_\_\_\_\_ 1.2 Тусгай зөвшөөрлийн дугаар: \_\_\_\_\_

1.3 Хэрэглэгчийн хаяг: \_\_\_\_\_

\_\_\_\_\_ 1.4 Холбоо барих утас: \_\_\_\_\_

**2. Тоног төхөөрөмжийн мэдээлэл:**

2.1 Нэр: \_\_\_\_\_ 2.2 Төрөл /марк/ \_\_\_\_\_

2.3 Тоо: \_\_\_\_\_ 2.4 Антенны марк, байршил \_\_\_\_\_

**3. Үйлчилгээний мэдээлэл:**

3.1 Үйлчилгээний төрөл : Телевиз	<input type="checkbox"/>	Тоон телевиз	<input type="checkbox"/>	MMDS	<input type="checkbox"/>
ФМ, Радио	<input type="checkbox"/>	Харилцааны станц	<input type="checkbox"/>	Үүрэн холбоо	<input type="checkbox"/>
WiFi	<input type="checkbox"/>	Бусад	<input type="checkbox"/>		

**4. Нөлөөллийн талаарх мэдээлэл:**

4.1 Нөлөөлөл үүссэн давтамж: \_\_\_\_\_

4.2 Нөлөөлөл мэдрэгдэх байдал: яриа  шуугиан  дохионы түвшний өөрчлөлт

4.3 Дамжуулах төрөл: тоон  аналог

4.4 Нөлөөллийн үргэлжлэх хугацаа \_\_\_\_\_ мин

4.5 Нөлөөллийг арилгах талаар танай байгууллагаас авсан арга хэмжээ \_\_\_\_\_

\_\_\_\_\_  
\_\_\_\_\_  
\_\_\_\_\_

Бүртгэлийн хуудсыг бөглөсөн: \_\_\_\_\_ /нэр, албан тушаал//утасны дугаар/ \_\_\_\_\_ /огноо/ \_\_\_\_\_ /гарын үсэг/



**ХЯНАЛТ ХИЙСЭН ИНЖЕНЕРИЙН БӨГЛӨХ ХЭСЭГ**

1. Албан бичгийн мэдээлэл: ирсэн  явсан

дугаар: \_\_\_\_\_

огноо: \_\_\_\_\_

товч утга: \_\_\_\_\_

Хуудасны тоо: \_\_\_\_\_

2. Хяналтын мэдээлэл:

Хяналт хийсэн огноо	Ашигласан тоног төхөөрөмж	Хяналтын үйл ажиллагааны талаарх тэмдэглэл	Хамтран хэмжилт хийсэн хүний мэдээлэл

3. Хэмжилтээр тогтоосон нөлөөллийн мэдээлэл:

3.1 Нөлөөллийн хугацааны давтамж: \_\_\_\_\_ 3.2 Нөлөөллийн төрөл: \_\_\_\_\_

3.3 Нөлөөллийн эх үүсвэр, шалтгаан: \_\_\_\_\_

4. Хяналтын үр дүн: \_\_\_\_\_

5. Дүгнэлт: \_\_\_\_\_

6. Авсан арга хэмжээ: \_\_\_\_\_

Бүртгэлийн хуудсыг бөглөсөн: \_\_\_\_\_ /нэр, албан тушаал/ \_\_\_\_\_ /утасны дугаар/ \_\_\_\_\_ /огноо/ \_\_\_\_\_ /гарын үсэг/

Маягт 2. Техник ашиглалтын паспорт

РАДИО ДОЛГИОНЫ ХЯНАЛТЫН ТӨВ

# ТЕХНИК АШИГЛАЛТЫН ПАСПОРТ №.....

Харилцаа холбооны зохицуулах хороо

Радио давтамжийн зохицуулалт хяналтын газар

Радио долгионы хяналтын төв

.....загварын

.....

/тоног төхөөрөмжийн нэр/

Эхэлсэн:.....он.....сар.....өдөр

Дууссан:.....он.....сар.....өдөр

# 1. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗОРИУЛАЛТ

---

1. Үйлдвэрлэсэн орны нэр: \_\_\_\_\_
2. Ашиглалтанд оруулсан огноо: \_\_\_\_\_
3. Ашиглалтанд хүлээн авсан актын №: \_\_\_\_\_
4. Төхөөрөмжийн серийн дугаар /Serial number/: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
5. Эд хогшлын дугаар: \_\_\_\_\_
6. Нягтлан бодох бүртгэлийн дугаар: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_
7. Ашиглах хугацаа /жил/: \_\_\_\_\_
8. Үзлэг үйлчилгээний хоорондох хугацаа: \_\_\_\_\_  
\_\_\_\_\_



## 2.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛИЙН ЖАГСААЛТ

№	Иж бүрдэлийн жагсаалт	Тоо ширхэг
1		
2		
3		
4		
5		
6		
7		
8		
9		
10		
11		
12		
13		
14		
15		
16		
17		
18		
19		
20		
21		

### 3. ТЕХНИКИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Техникийн үндсэн үзүүлэлтүүдийн жагсаалт	Хэмжигдэх нэгж	Тоон утга
1			
2			
3			
4			
5			
6			
7			
8			
9			
10			
11			
12			
13			
14			
15			
16			
17			
18			
19			
20			
21			







## 7. ТЕХНИКИЙН ПАСПОРТТАЙ АЖИЛЛАХ ДҮРЭМ ЖУРАМ

Энэхүү техникийн паспортыг РДХТөвийн инженерүүд гардан хөтөлнө.

1. Элэгдэх хугацаа, урсгал болон их засвар, үзлэг үйлчилгээний хоорондох хугацааг удирдлагаас тогтоосон журмын дагуу тодорхойлно.
2. Хэмжүүрийн багажийн иж бүрдэлийг нэг бүрчилэн жагсаан бичнэ.
3. Иж бүрдэлийг хагас жил, бүтэн жил тутамд тооллогод хамруулна.
4. Тоног төхөөрөмжийг хүлээн авч буй инженер нь хүлээн авч ашигласнаас хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд ажиллагааны хэвийн байдлыг алдагдуулахгүй байх үүрэгтэй.
5. Техникийн гэмтэл саатал гарсан тохиолдолд удирдлагад шуурхай мэдэгдэнэ.

**Бичиглэл:** Үсгийн фонт: New Roman, үсгийн хэмжээ-12

**ГАРЧИГ**

1. *Ажлын зорилго:*
2. *Ажил гүйцэтгэсэн хугацаа:*
3. *Хэмжилт, шалгалтын хамрах хүрээ:*
4. *Ашигласан хэмжүүрийн төхөөрөмж:*
5. *Ажлын хэсгийн бүрэлдэхүүн:*
6. *Хэмжилт, шалгалтаар хийгдсэн ажлууд:*
7. *Хэмжилт, шалгалтын явц, гүйцэтгэл:*
8. *Илэрсэн зөрчил, болон зөрчлийг арилгуулсан байдал:*
9. *Дүгнэлт:*
10. *Цаашид авах арга хэмжээний санал:*